



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/352

Булган сум

Г Нийлүүлэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Ковш худалдаж авах (Баяннуур, Дашинчилэн сум) нийлүүлэгчээр шалгарсан “Монтех дистрибьюшн” ХХК-тай 354,200,000 (гурван зуун тавин дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Давааням)-т олгосугай.

2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн аван данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Баяннуур сумын Засаг дарга (Б.Ёндөн), Дашинчилэн сумын Засаг дарга (С.Мэнд-Амар) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Монтех дистрибьюшн” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Ууганболд)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус барааны санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Энэ тогтоолыг 2025 оны 05 сарын 28-ны өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010485

Аймгийн Засаг даргын 2025. оны
05 дугаар сарын 28-ны/ний өдрийн
A/352 дугаар захирамжийн хавсралт

Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Бараа нийлүүлэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 90 хоногийн дотор	Г.Давааням
2	Баталгаат хугацаа	24 сар	Б.Ёндөн С.Мэнд-Амар
3	Чанаарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Б.Ариунболд Б.Ёндөн С.Мэнд-Амар
4	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд